



*Байгаль орчин менежментийн 2023 оны
төлөвлөгөө. МУ-021081
“Шохойт уул” уурхай*

**ХОВД АЙМГИЙН БУЯНТ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ
“ШОХОЙТ УУЛ” ШОХОЙН ЧУЛУУНЫ УУРХАЙН 2023
ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ХОВД АЙМАГ 2022 ОН.

АГУУЛГА

1. УУРХАЙН ТАНИЛЦУУЛГА.....	3
УУРХАЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	3
Компани нэр.....	3
Компаний хаяг.....	3
Уурхайн байршил.....	3
ТЕХНОЛОГИЙН ТОВЧ ТАЙЛБАР.....	4
УУРХАЙД АШИГЛАГДАЖ БУЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ.....	4
2. УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВАГДАЖ БУЙ НЭТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	5
Уурхайн талбайд хөрсний зүсэлт хийж үзэхэд дараах шинж тэмдгийг үзүүлж байна Үүнд:.....	
3. УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	7
УУРХАЙН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ:.....	7
Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх нөлөөлөл.....	7
Газрын хэвлийд нөлөөлөх нөлөөлөл.....	8
Агаарын чанарт үзүүлэх нөлөө, түүний үр дагавар:.....	8
Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө, түүний үр дагавар:.....	8
Амьтны аймагт үзүүлэх нөлөө, дүүний үр дагавар:.....	9
Гадаргын болон гүний усанд нөлөөлөх нөлөө:.....	9
УУРХАЙН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ:.....	9
Чимээ шуугиан:.....	10
Тоосжилт:.....	10
Хийн бохирдол:.....	10
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨДЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ:.....	10
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:.....	11
6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	12
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:.....	14
8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:.....	14
9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ:.....	15
10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ:.....	16
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР:.....	17
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД СУМ ОРОН НУТГААС САНАЛ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ:.....	18
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ:.....	19

УУРХАЙН ТАНИЛЦУУЛГА

Уурхайн ерөнхий мэдээлэл

“Шохойт уул” шохойн чулууны ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн хүрээнд тус ордыг ил аргаар олборлолт явуулж, Вестерн Холд ХХК-ий цементийн үйлдвэрийг шохойн чулууны түүхий эдээр ханган, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулахад мөн уул уурхайн салбарт түшиглэсэн үйлдвэрлэл, орон нутгийн түүхий эдэд тулгуурласан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлнэ гэсэн үндсэн зорилготой.

Ашигт Малтмалын Газраас “Вестернхолд” ХХК-д 103.94 гектар талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмал ашиглах эрхийг олгож MV-021081 дугаар бүхий гэрчилгээг 2018 оны 05 сарын 30-ны өдөр олгосон байна.

Уурхайн нэр:

“Шохойт Уул” шохойн чулууны уурхай

Компани нэр:

“Вестерн холд” ХХК , Регистрийн дугаар 4065115 , Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 1611002075, Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар- MV-021081 ,

Захирал С. Балжинням

Уурхайн хаяг:

Ховд аймгийн Буянт сумын Норжинхайрхан багийн нутаг

Уурхайн байршил

“Шохойт Уул” нэртэй шохойн чулууны орд нь засаг захиргааны нэгжийн хувьд Ховд аймгийн Буянт сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун тийш 1570 км-т,

Ховд хотоос зүүн хойш 15 км-т, Буянт сумаас урагш 12 км-т тус тус байрлана.


• Тусгай зөвшөөрлийн талбайн планшит: М-46-136

• Тусгай зөвшөөрлийн талбайн нийт хэмжээ: 103.94 га

Хүснэгт 1.Газарзүйн солбицол

Цэгийн дугаар	Талбайн солбицлууд	Газарзүйн солбицлын систем		
		Град	Мин	Сек
1	Уртраг	91	46	19.00
	Өргөрөг	48	05	12.00
2	Уртраг	91	45	29.44
	Өргөрөг	48	05	12.00
3	Уртраг	91	45	29.44
	Өргөрөг	48	05	36.63
4	Уртраг	91	45	54.16
	Өргөрөг	48	05	36.63
5	Уртраг	91	45	54.16
	Өргөрөг	48	05	53.00
6	Уртраг	91	46	19.00
	Өргөрөг	48	05	53.00



Зураг 1. Шохойн чулууны уурхайн байршлыг харуулсан агаар сансарын зураг:



Технологийн товч тайлбар

“Вестерн холд” ХХК нь жилд 300.0 мян.тн хүдэр олборлон борлуулах хүчин чадалтай байна. Шохойт уулын уурхай нь нийт ашиглалтаар 8,064.17 мян.тн шохойн чулуу олборлох бөгөөд төлөвлөсөн хүчин чадлаар ажиллахад үйлдвэрлэлийн нөөцийг 27 жилийн хугацаанд олборлохоор байна. Шохойт уулын шохойн чулууны уурхай нь ашиглалтын 1 -ээс 26 дахь жилд жил бүр 297.38-308.89 мян.тн шохойн чулуу олборлох бөгөөд ашиглалтын сүүлийн 27 дахь жилд 280.51 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар үйл ажиллагаа явуулна. Уурхайн ашиглалтын 27 жилийн хугацаанд нийт 14.7 мян.м³ хөрс /шимт хөрс/ хуулж, 8,064.17 мян.тн шохойн чулуу олборлоно. Хөрс хуулалтын дундаж коэффициент 0.003 м³/тн байна. Шимт хөрсийг утгуурт ачигчаар автосамосвалд ачин, дунджаар 380 м зайд автосамосвалаар тээвэрлэн шимт хөрсний овоолгод овоолно.

Уурхайд ашиглагдаж буй тоног төхөөрөмж.

Д/д	Машины механизмын нэрс	Тоо	Зураг
1	Экскаватор	2	
2	Ковш	3	
3	Бульдозер	1	
4	Автогрейдер	1	
6	Автосамосвал	4	
7	Усны машин	1	
9	Автобус/Ажилчдын/	1	

1. УУРХАЙН ОЛБОРЛОТ ЯДАГДАХ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Газарзүйн бүсчлэлд хамаарах байдал: Байгалийн мужлалын хувьд Төв Азийн өндөрлөг, Хангайн уулт өндөрлөгийн хойт хэсгийн дундаж өндөрлөг уулс бүхий ар хажуугийн ой хээр, тайгын дэд мужид хамаарах хээр, умард хуурай хээр, нуга, ар хажуугийн ой бүхий районд хамаарна. Тус талбайд дээд дөрөвдөгчийн болон орчин үеийн голын хурдас хуримтлагдсан. Буянт сум нь Алтайн уулархаг муж, Их нууруудын сав газарт 367950 га нутаг эзлэн оршдог. Төслийн талбай орчмын район нь гадаргын хувьд дундаж өндөр уул, нам уул, уул хоорондын хөндий, налуу тал гэсэн хотгор гүдгэрийн үндсэн хэв шинжүүдэд хамаарагдана. Геоморфологийн мужлалаар Сибирийн геоморфологийн их муж, Монгол Алтайн мужийн Монгол Алтайн өмнөдийн дэд мужид хамрагдана.

Цаг уур, уур амьсгалын товч тодорхойлолт: Судалгааны нутагт хамрагдах Ховд хот орчмын район нь уур амьсгалын мужлалтын хувьд гандуу дулаан зунтай, хахир хүйтэн өвөлтэй, хээрийн ба цөл хээрийн шилжилтийн бүсэд хамрагдана. Ховд хот түүний орчмын уур амьсгал нь дэлхийн умард сэрүүн бүсийн эх газрын эрс тэс уур амьсгалын ерөнхий зүй тогтолтой бөгөөд энэ нь Их Нууруудын Хотгорын байгаль цаг уурын онцлог, газарзүйн байршил, гадаргын өндөр, хүрээлэн байгаа уул нуруудаас ихээхэн хамаардаг.

Уурхайн үйл ажиллагаанд нөлөөлөх цаг уурын үзүүлэлтүүд:

Агаарын температур: Ховд хот нь хүйтэвтэр урт өвөлтэй, халуун богино зунтай, хавар намар нь урт үргэлжилдэг. Ховд хот орчмын районы агаарын 1 дүгээр сарын дундаж температур нь -25.5°C , 7 дугаар сарын агаарын дундаж температур нь $+19.1^{\circ}\text{C}$, жилийн дундаж агаарын температур нь -0.5°C орчим байна.

Хүснэгт 3. Ховд хотын уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлтүүд

№	Үндсэн үзүүлэлтүүд	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
1	Температур	-25.5	-20.7	-7	4.4	11.1	17.1	19.1	17	10.8	1.8	-10.4	-21.4
2	Тунадас (мм-ээр)	2	2	2	5	14	18	30	30	11	4	2	2
3	Салхи (м/с-ээр)	0.8	1.2	1.9	2.9	2.8	2.1	1.8	1.7	1.8	1.9	1.7	1
4	Даралт (мб-аар)	865.3	863.3	860.4	860	858.3	855.7	854.3	856.6	860.1	862.7	863.8	864.6

Салхи: Ховд хотын салхины зонхилох чиглэл нь баруун хойноосоо зүүн урагш голлон салхилдаг бөгөөд "Бадамлах Дөл" Дулаан түтээх төвийн байршил нь салхины зонхилох чиглэл болоод газрын өндөршил, бохирдол тархах байдал зэргийг бодолцож байрлуулсан буюу өөрөөр хэлбэл, бололцоотой бусад байршилудтай харьцуулахад хамгийн оновчтой байрлалд байрласан гэж хэлж болохоор байна.

Гадаргын усан сүлжээ: Гидрогеологийн мужлалаар тус район нь Түү зуурын элбэг тэжээлтэй ай савын хэсэг болох Монгол Алтайн депрессид хамаарагдана. Төсөл хэрэгжиж буй бүс нь гол, эх газрын нуурын гаралтай хурдас дахь дундаж ундаргатай уст давхрагаас бүрдэх ба Дөрөвдөгчийн элс, хайрганцар, элсэнцэр, сайр, сайрганцар мөн Дээд цэрдийн элсжин, элс, хөрсөн, хайргажин зэрэг бүрдэлтэй байна. Төслийн талбайн районы төв хэсгээр дайран өнгөрөх Буянт гол нь Монгол Алтайн хойд хажуугаас эх аван урсдаг. Буянт голын судалгааны районд хамрагдах хэсэг нь 28км үргэлжлэх бол энэ орчимд урсгалын хурд нь 2.5 м/сек, гүн нь 0.4-1 м байна.

Хөрс: Төсөл хэрэгжиж буй талбай нь Монгол орны хөрс - газар зүйн мужлалаар Төв азийн хөрс - био уур амьсгалын их мужийн Говийн их мужийн Монголын өрнөд дэд мужын Хяргас-Хар нуурын тойрогт хамаарна.

Уурхай хэрэгжих талбайд хөрсний зүсэлт хийж үзэхэд дараах шинж тэмдэгийг үзүүлж байна. Үүнд:
Микро рельефийн хувьд уулын хажуу бэл, гадаргын налуу 4°

Ургамлын бүлгэмдэл: Цөлөрхөг хээрийн бүлгэмдэл

Ургамлын бүрхэц: 19%

Хөрс: Цөлөрхөг хээрийн бор хөрс

А үе 0-10см. Цайвар бор өнгөтэй, ургамлын үндэс дунд зэрэг, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, бүтцийн хувьд жижиг бөөмөрхөг, хуурай, хил тэгш, нягтавтар, шилжилт аажим, давсны хүчлийн уусмалд сул буцалж байна.

В үе 10-58см. Цайвар бор өнгөтэй, ургамлын үндэсгүй элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, нягтавтар, чийглэг, шилжилт аажим, хил долгиорхог, давсны хүчлийн уусмалд сул буцалж байна.

С үе 58-80см. Зэгэл саарал өнгөтэй, ургамлын үндэсгүй, нягтавтар, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй чийглэг, давсны хүчлийн уусмалд буцалж байна.

Ургамал: Ургамал газар зүйн мужлалтын хувьд тус район нь Евроазийн хээрийн их мужийн, Төв азийн муж, Алтайн хээрийн дэд хэв шинжийн ургамалтай.

Амьтад: Зөвхөн төлөвлөж буй шохойн чулууны орд орчмын амьтны аймгийг ялгаж тодорхойлох нь учир дутагдалтай бөгөөд үүнийг Ховд аймгийн Буянт сумын эдэлбэр газрын хэмжээнд авч үзэх нь оновчтой болох юм. Энэ орчмын ногоон бүсийн нутагт алаг шунгаач (*Vesperhala clangula*), намгийн цагаан элэгт (*Circus aeruginosus*), ханамал хөхөө (*Cuculus saturatus*) зэрэг шувуу хэвийн хэмжээнд, ангир (*Tadorna ferruginea*), зэрлэг нугас (*Anas platyrhynchos*) зэрэг шувуу элбэг, идлэг шонхор (*Falco cherrug*), үнэсэн дүнхай (*Lanius excubitor*), монгол зэрүүлт болжмор (*Pygilauda davidiana*) зэрэг шувуу ховор, хээрийн хөхтнөөс монгол тарвага (*Marmota sibirica*) цөөн, урт

сүүлт зурам (Citellus undulatus) хэвийн, дагуур огодой (Ochotona plallacil) элбэг, зэрлэг туурайтнаас зэрлэг гахай (Sus scrofa) зэрэг элбэг байдаг.

3 УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Уурхайн гол сөрөг нөлөөлөл тодорхойлолт :

Ховд аймгийн Буянт суманд байрлах “Шохойт уул” шохойн чулууны уурхайн үйл ажиллагаа явуулах үед байгаль орчны төлөв байдалд үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд нь дараах байдалтай байна. Үүнд:

- > Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөө
- > Газрын хэвлийд үзүүлэх нөлөө
- > Агаарын чанарт үзүүлэх нөлөө
- > Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө
- > Амьтны аймагт үзүүлэх нөлөө
- > Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөө

Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх нөлөөлөл:

Хүснэгт 4. Уурхайн олборлолтоос хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх үр дагаврын чанарын үнэлгээ

№	Сөрөг нөлөөлөл	Үр дагаврын чанарын үнэлгээ				
		Нөлөөгүй I	Бага II	Дунд III	Их IV	Сүбсний V
1	Хөрсний элэгдэл, эвдрэл				+	
2	Техникийн нөлөөлөл				+	
3	Шатах тослох материал хөрсөнд нэвчих		+			
4	Ахуйн болон техникийн хог хаягдлаар бохирдох			+		
5	Тоосжилтын нөлөөгөөр хөрсөн бүрхэвч үржил шимгүй болох				+	

Тайлбар: Уурхайн олборлолтоос хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх үр дагаврын чанарын үнэлгээ бага буюу II (20%), дунд буюу III (20%), их буюу IV (60%) байна. Хөрсөн бүрхэвчид сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй сөрөг нөлөөллүүд нь шатах тослох материал алдагдсанаас хөрсөн бүрхэвч бохирдох мөн ахуйн болон техникийн гаралтай хог хаягдлаар бохирдох юм. Эдгээр сөрөг нөлөөллүүд нь ажилчдын анхаарал болгоомж, өдөр тутмын ажлын бүтээмжээс хамаарах учир болзошгүй сөрөг нөлөөлөл юм. Харин тоосжилт, машин техник, шохойн чулуу олборлох үйл явц нь хөрсөн бүрхэвчинд их хэмжээний сөрөг нөлөөлөл учруулах буюу гол сөрөг нөлөөлөл болж байна.

Шохойн чулууны уурхай нь ашиглалт явуулах талбайдаа хөрсийг хуулж авах буюу хуулах боломжгүй нимгэн хэсгээр шууд тэсэлгээ хийж олборлолт явуулахаар төлөвлөж байна. Ингэснээр ашиглалтын талбайн хөрсөн бүрхэвч бүрэн байхгүй болох бөгөөд гүн нүх үүсгэн ашиглах учраас дараа дахин нөхөн сэргээхэд бэрхшээлтэй болох юм. Мөн олборлолт явуулах үед боссон тоос шороо нь ойр орчны эрүүл хөрсөнд бууснаар ургамлан бүрхэвч болоод хөрсний чанарт сөргөөр нөлөөлөх болно. Олборлолтын хэрэгцээнд ашиглагдах автомашин, тээврийн хэрэгслүүд шатахуун тос болон цаг хэмнэх үүднээс зам товчлон замгүй газраар явж хөрсөн бүрхэвчийг гэмтээж болзошгүй юм.

Газрын хэвлийд нөлөөлөх нөлөөлөл:

Шохойт уулын уурхай нь нийт ашиглалтаар 8,064.17 мян.тн шохойн чулуу олборлох бөгөөд төлөвлөсөн хүчин чадлаар ажиллахад үйлдвэрлэлийн нөөцийг 27 жилийн хугацаанд олборлохоор байна. Шохойт уулын шохойн чулууны уурхай нь ашиглалтын 1 -ээс 26 дахь жилд жил бүр 297.38-308.89 мян.тн шохойн чулуу олборлох бөгөөд

ашиглалтын сүүлийн 27 дахь жилд 280.51 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар үйл ажиллагаа явуулна. Уурхайн ашиглалтын 27 жилийн хугацаанд нийт 14.7 мян.м³ хөрс /шимт хөрс/ хуулж, 8,064.17 мян.тн шохойн чулуу олборлоно. Хөрс хуулалтын дундаж коэффициент 0.003 м³/тн байна.

Хүснэгт 5. Уурхайгаас газрын хэвлийд нөлөөлөх үр дагаврын чанарын үнэлгээ

№	Сөрөг нөлөөлөл	Үр дагаврын чанарын үнэлгээ				
		Нөлөөгүй I	Бага II	Дунд III	Их IV	Сүүрлийн V
1	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх				+	
2	Геологийн тогтцын өөрчлөлт				+	
3	Газрын хэвлийн нөөц ашиглалт				+	

Тайлбар: Шохойн чулууны орд ашиглах нь газрын хэвлийгээс шохойн чулуу тэсэлж олборлох буюу ил уурхайн аргаар үйл ажиллагаа явуулдаг учраас газрын гадаргын хэлбэр төрхийг болон газрын хэвлийн нөөцийн хэмжээг өөрчлөх сөрөг нөлөөллийг үзүүлнэ. Үр дагаврын чанарын үнэлгээгээр их буюу IV (100%) байна. Эндээс дүгнэхэд байгалийн баялгыг ашиглах буюу шохойн чулуу олборлох үйл явц нь төслийн гол сөрөг нөлөөлөл байна.

Агаарын чанарт үзүүлэх нөлөө, түүний үр дагавар

Хүснэгт 6. Уурхайгаас агаарын чанарт нөлөөлөх үр дагаврын чанарын үнэлгээ

№	Сөрөг нөлөөлөл	Үр дагаврын чанарын үнэлгээ				
		Нөлөөгүй I	Бага II	Дунд III	Их IV	Сүүрлийн V
1	Авто машинаас ялгарах хорт хий			+		
2	Авто машины дуу чимээ		+			
3	Тэсэлгээнээс үүсэх тоосжилт		+			

Тайлбар: Уурхайгаас агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийн үр дагаврын чанарын үнэлгээгээр бага буюу II(75%), дунд буюу III (25%) гэсэн үнэлгээтэй гарлаа.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө, түүний үр дагавар

Хүснэгт 7. Уурхайгаас ургамлан бүрхэвчинд нөлөөлөх үр дагаврын чанарын үнэлгээ

№	Сөрөг нөлөөлөл	Үр дагаврын чанарын үнэлгээ				
		Нөлөөгүй I	Бага II	Дунд III	Их IV	Сүүрлийн V
1	Машины зогсоол, зам, барилга байгууламжинд дарагдаж ургамлан бүрхэвч устах				+	
2	Тоосжилтын улмаас ургамлын ургалтанд сөргөөр нөлөөлөх				+	
3	Бэлчээрийн хомсдол үүсэх			+		

4	Замгүй газраар машин явсны улмаас ургамлан бүрхэвч доройтох		+			
5	Хог хаягдлын улмаас ургамлын ургалтанд сөргөөр нөлөөлөх		+			

Тайлбар: Уурхайгаас ургамлан бүрхэвчинд нөлөөлөх үр дагаврын чанарын үнэлгээ бага буюу II (40%), дунд буюу III (20%), их буюу IV (40%) байна. Төслийн хүрээнд авто замыг шийдэж өгсөн тул замгүй газраар тээвэр хийх тохиолдол бараг гарахгүй тул энэ нь болзошгүй сөрөг нөлөөлөл юм. Харин барилга байгууламжид дарагдах болон шохойн чулуу олборлох үйл явц болон тоосжилт нь ургамлан бүрхэвчид ихээхэн сөрөг нөлөөлөл учруулахаар байна.

Амьтны аймагт үзүүлэх нөлөө, түүний үр дагавар.

Хүснэгт 8. амьтны аймагт нөлөөлөх үр дагаврын чанарын үнэлгээ

№	Сөрөг нөлөөлөл	Үр дагаврын чанарын үнэлгээ				
		Нөлөөгүй I	Бага II	Дунд III	Их IV	Сүйрлийн V
1	Амьтдын амьдрах орчин талхлагдах			+		
2	Идэш тэжээл хомсдох			+		
3	Ухсан нүх, хонхорт унаж бэртэх, зүйлийн тоо цөөрөх		+			
4	Дуу чимээний нөлөөгөөр үргэж дайжих			+		
5	Хууль бус ан агнах	+				

Тайлбар: Уурхайгаас амьтны аймагт нөлөөлөх үр дагаврын чанарын үнэлгээ нөлөөгүй буюу I (20%), бага буюу II (20%), дунд буюу III (60%) байна. Иймд төслөөс амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл дунд буюу III гэж үзлээ.

Гадаргын болон гүний усанд нөлөөлөх нөлөөлөл.

Хүснэгт 9. Уурхайгаас усан орчинд нөлөөлөх үр дагаврын чанарын үнэлгээ

№	Сөрөг нөлөөлөл	Үр дагаврын чанарын үнэлгээ				
		Нөлөөгүй I	Бага II	Дунд III	Их IV	Сүйрлийн V
1	Гүний усны хэрэглээ		+			
2	Олборлолтын явцад гүний усны урсгалын чиглэл, хэмжээ өөрчлөгдөх, нөөц алдагдах	+				

Тайлбар: Уурхайгаас үндсэн үйл ажиллагааны үед усан орчинд нөлөөлөх үр дагаврын чанарын үнэлгээ нөлөөлөлгүй буюу II (20%) байна.

Уурхайгаас болзошгүй сөрөг нөлөөллийн тодорхойлолт :

Ховд аймгийн Буянт суманд байрлах Шохойт шохойн чулууны уурхайн үйл ажиллагаа явуулах үед байгаль орчны төлөв байдалд үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд нь дараах байдалтай байна. Үүнд:

- > Чимээ шуугиан
- > Тоосжилт
- > Хийн бохирдол

Чимээ шуугиан

Шуугиан ба доргио нь хүрээлж буй орчинд хэлбэлзэх долгион хэлбэрээр тархаж, хүн, амьтан, ургамалд сөрөг нөлөө үзүүлдэг. Уурхайн дуу чимээ нь ойр орчмын цэрлэг ан амьтад үргэж дайжиж болзошгүй.

Тоосжилт

Тоосжилт нь уурхай болон газар шорооны ажлын агаар бохирдолтонд нөлөөлдөг хамгийн түгээмэл тулгардаг асуудал юм. Дараах уурхай, газар шорооны ажлууд тортог бий болгодог.

- тэслэлт, олборлолт, тээвэрлэлт, дамжуулга, өрөлт, ачилт, буулгалт
- нээлттэй талбайг цэвэрлэх
- хатуу хучилт хийгдээгүй замаар тээвэр хийх
- хаягдал хадгалах талбайн хатсан өнгөн гадаргууд тоосжилтын эсрэг арга хэмжээ авагдаагүй байхад ашиглах (ялангуяа дээгүүр нь тоног төхөөрөмж явуулах)

Авто машины хийн бохирдол

Тээврийн хэрэгслийн утааны найрлага болон түлшний шаталтын бүтээгдэхүүнээс хүрээлэн буй орчин, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ, цар хүрээ хамаарч байдаг. Зарцуулагдах түлшний жингийн 15% нь ашигтай зарцуулагдаж, үлдсэн 85% нь агаарт цацагддаг байна. 1кг түлш шатахдаа бензиний хөдөлгүүр 300-310г, дизель хөдөлгүүр 80-100г хорт бодис ялгаруулдаг байна. Тээврийн хэрэгслийн утаанаас агаарын бохирдуулалтыг тодорхойлохдоо, бензиний хөдөлгүүрт бол нүүрстөрөгчийн ба азотын ислийн агуулалтыг, дизель хөдөлгүүрт бол хөө тортгийн агуулалтыг үндсэн үзүүлэлт болгодог.

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Уурхайг хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан гол сөрөг нөлөө болон болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахад чиглэгдсэн байгаль хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж төслөөс үүдэн гарах байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, хамгаалахад гол зорилго нь оршино.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Агаарын чанар	Тэсэлгээ, буталгаа хийх хугацаа болон байршлуудад харгалзуулан салхи ихтэй үеүдэд болон уурхайгаас үйлдвэр хооронд тээвэрлэлт хийх замыг тогтмол хугацаанд тээвэрлэлт усалж, чийгшүүлэн нягтаршуулах. Тоосжилтыг усаар шүрших уламжлалт арга хэрэглэж байгаа боловч усны зарцуулалт өндөр, хуурай цаг уурт тохироогүй, үр бүтээл багатай эдийн засгийн хувьд өндөр өртөгтэй тул тоос дарах барьцалдуулагч бодис ашиглах туршилт судалгаа хийх.	Уурхай, Үйлдвэр хоорондын тээвэрлэлтийн зам Уурхайн олборлолтын талай	- -	- -	- -	- -	2023 оны дулааны улиралд 4-10р сар 2023	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016
2	Хөрсөн бүрхэвч	Шатах тослох материал хадгалах, засвар хийх талбайг үер, галын аюулд өртөхөөргүй газарт сонгон байрлуулж, шатах тослох материал санамсаргүй тохиолдлоор асгарахаас урьдчилан сэргийлж элс хайрган хучилт хийж өгөн, анхааруулах тэмдэг тэмдэглэгээг хийж байрлуулна "Шохойн уул" уурхайн талбайн дотор ба гадна орчны авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зохицуулах тэмдэг, тэмдэгжүүлэгчийг нэмэгдүүлэх, сэргээн засварлах	Уурхайн талбай Уурхайн талбай, Үйлдвэр хоорондын зам	төгрөг төгрөг	150,000 150,000	1 удаа 1 удаа	150,000 150,000	2023 он 2023 он	Хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008
4	Амьтны аймаг	Зэрлэг ам амьтан(Янгир) идэш гэжээл хомсодсон үед биотехникийн арга хэмжээ амах(Өвс, Хужир мараа тавих) . Судалгаа хийх.	Уурхайн нөлөөллийн бүс	боодол кг	14,000 1,600	25 100	350,000 160,000	2023 оны 4-5р сар	
	нийт						810,000 төгрөг		

6.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1.	Техникийн нөхөн сэргээлт	2023 онд техникийн нөхөн сэргээлт хийгдэхгүй	-	-	-	-	-	-
2.	Биологийн нөхөн сэргээлт	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр мод тарих, тарьсан модыг арчил, тордох Мод тарих, ургамлын нөмрөгийг сайжруулах замаар арчилж тордох, услах, чийгшүүлэх	-	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгав			2023 онд	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. MNS 5918:2008
	Нийт							

7.БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
Хүснэгт 12. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгааллын зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, би	Баривчлах эрх зүйн баримт бичиг
1	1	2	3	4	5	6	7	8
2	Уурхайн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах, багасгах арга хэмжээ	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2023 оны 5-р сард 1000ш Шар хуягс, Хайлаас, Улиас мод тарьж, тарьсан модыг арчилж, тордох ургамлын нөмрөгийг сайжруулах замаар арчилж тордох, услах, чийгшүүлэх	Уурхайн нөлөөллийн бүс	1000 ш	2,100	2,100,000	2023 оны 5-р сар	Мод, сөөгийн тарьц. Техникийн шаардлага MNS 6140: 2010
		Тарьсан тодыг мал, амьтан, хувь, машинаас хамгаалах ургалтыг үйл явцыг хэвийн байлгах зорилгоор 696м урт газрыг хашиж хамгаалах	Үйлдвэрийн хашаанаас засмал засмал зам хүртлэх 340 м хатуу хувилттай замын зүүн тал	төмөр тор боодол	1ш-180,000	14ш-2,520,000	2023 оны 5-сар	
				ширхэг төмөр шон	1ш-14,000	190ш-2,660,000		
Нийт			7,280,000					



*Байгаль орчин менежментийн 2023 оны
төлөвлөгөө. МУ-021081
“Шохойт уул” уурхай*

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ховд аймгийн Буянт суманд байрлах “Шохойт уул” шохойн чулууны уурхайн ашиглалтын газрыг хувь хүн, албан байгууллага эзэмшиж ашигладаггүй байсан тул нүүлгэн шилжүүлэлт ба нөхөн олговор олгох арга хэмжээ авах боломжгүй юм.

9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ховд аймгийн Буянт суманд байрлах “Шохойт уул” шохойн чулууны уурхайн газарт одоогийн байдлаар археологи, палеонтологи, түүх, соёлын дурсгалт зүйлс илрээгүй. Илэрсэн тохиодолд мэргэжлийн байгууллагад хандан заавар зөвлөгөө авч хамгаалуулна.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
Хүснэгт 14. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга, хэмжээ	Арга хэмжээний тоо цэг, хурээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Байгалын гамшиг, гала түймэр гарах	Түймэр үер усны аюулаас сэргийлэх тэдгээртэй тэмцэх багаж хэрэгслийн тоо хэмжээг хүчин чадлыг нэмэгдүүлэх, хяналт тавих	Ажлын байр	6	50.0	300.0	2023 онд	
2	Ажилчдын аюулгүй байдлыг хангах	Нийт ажилчдад байгалийн гамшиг(үер ус, салхи шуурга, гала түймрийн аюул осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах.	Нийт ажилчид	1	50.0	50.0	2023 онд	
Нийт				350 000				



Байгаль орчин менежментийн 2023 оны
төлөвлөгөө. МУ-021081
“Шохойт уул” уурхай

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгж-үүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
		Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, тогтоосон цэгт зориулалтын саванд хаягдал		төгрөг	300.0	1	300.0		

Western Hold Co., Ltd.



12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын төрлийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, аргачлал	орч.
	1	2	3	4	5	6	7	8	
Агаар	Тоосжилтын бохирдлын хэмжээ	Уурхайн олборлолтын талбайн ачаалал ихтэй бүх хэсэгт	Жилд удаа	1	25.0	25.0	150мгр\м³	Агаар бохирдуулагч бодисын хэмжээ	хэм
	Хүхэрлэг хийн агууламж(SO₂)				25.0	25.0	150мгр\м³		
	Метан болон бусад шатамхайн хийн агууламж				25.0	25.0	3мгр\м³		
Хөрс	Хөрсний химийн шинж	1. Овоолго 2. Ашиглалтын мөргөцөг 3. Бусад	Жилд удаа	1	20.0	60.0	1. ялзмагийн хэмжээ 15-20 мгр\кг	Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох MNS 3310-91	агро
	Хөрсний урвалын орчин						2. Карбонат 21мгр\кг 3. Азот 5,9 мгр\кг Фосфор 1,8 мгр\кг		
Ус	Усан дахь нефть бодисын агууламж	1. Орчны гадаргийн ус 2. Олборлотын явцал гарсан гүний ус	Жилд удаа	1	50.0	100.0	0 мгр\л	Усан орчны чанарын үзүүлэлт MNS 4586-98	
	Усны орчин						7-8.5		
	Биохимийн хүчилтөрөгч хэрэгцээт						6,5- 8,4 мгр\л		
нийт		185,000							



13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД
СУМ ОРОН НУТГААС САНАЛ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ

Хүснэгт 17. Сум орон нутагт хийгдэх ажил

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хувиарь			Хариуцсан албан тушаалтан	Төйлбөр
			2023 он	Сар ...	Сар ...		
1		2	3	4	5	6	7
1.	Байгаль орчны асуудлыг орлогч захирлын түвшний албан тушаалтанд хариуцуулан эзэнтэй болгож ерөнхий захирал өөрөө хяналт тавин ажиллах.	-	-	-	-	Ерөнхий захирал	
2.	Ховор ан амьтан хамгаалах, биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах.	Дотоод төсвөөр	-	-	-	Байгаль орчны мэргэжилтэн	
3.	Холбогдох газрын захиргаатай байгаль хамгаалах талаар ажил төрлийн холбоотой байх.	-	-	-	-	Ерөнхий захирал Байгаль орчны мэргэжилтэн	
4.	Тус сумын Хөх булангийн 2 га эвдэрсэн газрыг нөхөн сэргээх.	Дотоод төсвөөр	-	-	-	Ерөнхий захирал Байгаль орчны мэргэжилтэн	
5.	Тус сумын Наран хайрхан багийн Дам усны булгийн эхийг тохижуулах.	Дотоод төсвөөр	-	-	-	Ерөнхий захирал Байгаль орчны мэргэжилтэн	
Нийт							

**14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БНЭГЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСНИЙ ОРШИН СУУТЧДАД ТАЙЛАГНАХ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 18. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биеэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ-ийг тайлагнахад ороцогч талууд	Биеэлтийг тайлагнах хэсгээр	Мэргэжлийн агуулга	Эхэлсэн байгуулах хугацааны төг	Тайлагнах зардал, төг	Хариуцаж байгуулах тушаалтан/ажалтан	Зохсон албан байгуулах газар	Зохсон байгуулах газар
1	2	3	4	5	6	7	8	
4.	Харьяалагдах нийслэлийн газар	аймаг Байгаль орчны	хувь БОМТ-ын хэрэгжилтийн талаарх бүрэн дотор тайлан	11 сарын 1ний дотор		Экологич		
5.	БОМТ-ын ажлын хэсэг	хянах хянах талбайд	Уурхайн БОМТ-н хэрэгжилтийг газар дээр нь хянуулж, үнэмлэлт дүгнэлт авах	11-р сарын 30 ны дотор		Экологич		
6.	Байгаль орчны эрхэлсэн Төрийн төв байгууллага	асуудал захирагчын бичгээр санал авна	Тайлангаар БОМТ-ний хэрэгжилт танилцуулах, дараа жилийн БОМТ-г батлуулах	оны 12-р сарын 30ний дотор		Экологич		
Нийт								



MV-021081 тоот "Шохойт Уул" Шохойн чулуун уурхайн 2023 оны БОМТөлөвлөгөө

Хүснэгт 19. 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгтгэл

№	Төлөвлөгөө	Зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	810,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	7,280,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	350 000
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	300 000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	185 000
9	"Шохойт уул" уурхайн 2023 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөнд сум орон нутгаас санал авч хийх ажил	-
10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	
НИЙТ	төгрөг	8,925,000

“ВЕСТЕРНХОЛД” ХХК-НИЙ “ШОХОЙТ”-ИЙН ЦЕМЕНТИЙН УУРХАЙГ АШИГЛАХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ХУУДАС

1. Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр “Вестерн Холд” ХХК
2. Төслийн байршил: Буянт сум, Норжинхайрхан баг
3. Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-021081
4. Огноо: 2022.12.05

№	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Авсан байвал зохих оноо	Ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн оноо									Гишүүдийн үнэлсэн онооны энгийн арифметик дундаж	Үндэслэл, тайлбар
			1	2	3	4	5	6	7	8	9		
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	13	14
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	20	25	20	25	20	23	23	25	25	25	23.4	Сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн тодорхой арга хэмжээг төлөвлөн үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай.
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт /техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлт, татан буулгах, хаалтад бэлтгэх/	30	30	30	30	25	30	30	30	25	30	28.88	Шимт хөрсний хадгалалт хамгаалалт, нөхөн сэргээлтийг ажлыг стандартын дагуу хийгээгүй.
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	5	-	-	-	-	-	-	-	-	-	-	
6	Осол, эрсдэлийн менежментийн	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	

	төлөвлөгөөний биелэлт												
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	
10	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	4	5	5	5	4.88	Иргэдийг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах шаардлагатай.
	Нийт оноо	100	100	95	100	90	98	97	100	95	100	97.2	

Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгөөнд тусгагдаагүй тул сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд шилжүүлж тооцов.

Төслийн тухайн жилийн байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийг 97.2 хувьтай хэрэгжсэн гэж дүгнэв. Ажлын хэсгийн саналыг хавсаргав.

Ажлын хэсгийн дарга:

Байгаль орчин, аялал жуулчлалын дарга

Л.Батбаяр

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын газар, газрын хэвлий, нөхөн сэргээлт, БОНБУ-ний асуудал хариуцсан мэргэжилтэн

Т.Маралмаа

Г.Маралмаа

Гишүүд:

Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч

Х.Мөнхжаргал

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны асуудал

хариуцсан мэргэжилтэн

Буянт сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч

Хар нуур Ховд голын сав газрын захиргааны
ус ашиглалт хариуцсан мэргэжилтэн

Буянт сумын Засаг дарга

Буянт сумын байгаль хамгаалагч

Нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл

Хүлээн зөвшөөрсөн:

"Вестерн Холд" ХХК-ний Гүйцэтгэх захирал



Т.Бямбажаргал

Д.Эрдэнэзаяа

Э.Оюунтунгалаг

Б.Түвшинсайхан

Б.Бахтяр

А.Самархан



С.Балжинням

**“ВЕСТЕРН ХОЛД” ХХК-НИЙ “ХОВД ЭКО ЦЕМЕНТ” БАРУУН БҮСИЙН ЦЕМЕНТИЙН
ҮЙЛДВЭР, “ШОХОЙТ УУЛ” ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРД АШИГЛАХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АНХААРАХ АСУУДАЛ, 2023 ОНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАХ САНАЛ**

2022.12.05

Ховд хот

Анхаарах асуудал:

1. Мод тарих ажлыг мэргэжлийн байгууллага, орон нутгийн захиргааны зөвлөмж чиглэлийн дагуу нарийвчлан төлөвлөж тусгайлсан талбайд үр дүнтэй зохион байгуулах.
2. Хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах боломжтой хог хаягдлыг холбогдох газруудад хүргүүлэх, аюултай хог хаягдлын ашиглалт хамгаалалтанд анхаарч мэргэжлийн байгууллагад нийлүүлэх.
3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах.
4. Сум орон нутаг, багийн иргэдийг хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллээр хангах.
5. Менежмент төлөвлөгөөний биелэлтэнд усны талаар оруулах.
6. Ундны усанд зам тавихад яаж нөлөөлсөн талаар мэдээ тайлан оруулах.
7. Ус ашигласны төлбөр, баримт тусгах.
8. Усны талаарх мэдээллээ хүргүүлж байх
9. Худгийн барилга байгууламж барих, тоолуур тавих, камер тавих
10. Ундны усыг хамгаалалтанд авах.
11. Ажилчдын нийгмийн асуудал, зан харилцааны тал дээр анхаарах.
12. Түгээмэл тархацтай байгалийн баялаг ашиглах газрын зөвшөөрөл авах.
13. Байгаль орчны ажилтнуудаа чадваржуулах, ажилтнаа тогтвор суурьшилтай ажиллуулах.

2023 оны төлөвлөгөөнд тусгах санал:

1. Ховор ан амьтан хамгаалах, биотехникийн арга хэмжээ авах.
2. Тус сумын Наранхайрхан багийн Дам усны булгийн эхийг тохижуулах.
3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих.
4. Тус сумын Хөх булангийн 2 га эвдэрсэн газрыг нөхөн сэргээх.
5. Буянт гол дагуу хамгаалалтын зурвас тогтоож тэмдэгжүүлэх.
6. Байгалийн гамшиг болон онцгой байдал үүссэн тохиолдолд техник, тоног төхөөрөмжөөр туслах, дэмжлэг үзүүлэх.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

